



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 06 сарын 12 өдөр

Дугаар 207

Улаанбаатар хот

“Нэткапитал Финанс Корпораци ББСБ”
ХХК-ийн хаалттай өрийн бичгийг
бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Компанийн тухай хуулийн 41.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 248 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагаас гаргах хаалттай өрийн бичгийг бүртгэх журам”-ын 2.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Нэткапитал Финанс Корпораци ББСБ” ХХК-ийн гаргасан 12 сарын хугацаатай, нэг бүр нь 1,000,000/нэг сая/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1,600 ширхэг, нийтдээ 1,600,000,000 /нэг тэрбум зургаан зуун сая/ төгрөгийн үнийн дүн бүхий хаалттай өрийн бичгийг бүртгэхийг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/-т үүрэг болгосугай.

2. Холбогдох хууль тогтоомж болон Хорооноос баталсан журмаар хүлээсэн үүргээ чанд мөрдөж ажиллахыг “Нэткапитал Финанс Корпораци ББСБ” ХХК/Н.Ундрах/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000358